

АУДИТЫН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРИЛГА

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар нь төсвийн байгууллагуудын 2021 оны санхүүгийн тайланд гэрээгээр аудит хийх хараат бус аудитын хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хуулийн этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

Энэхүү аудитын үйлчилгээ нь Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т заасны дагуу төсвийн захирагчдын санхүүгийн тайланд аудит хийх чиг үүргээ аудитын хуулийн этгээдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх шаардлагын дагуу зарлагдаж байгаа болно.

1.Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараах мэдээлэл болон холбогдох бичиг баримтыг нотлох баримтын хамт ирүүлнэ үү. Үүнд:

- Улсын бүртгэлийн гэрчилгээ, аудит хийх тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа нь тухайн жилд аудит хийх хуулийн цаглавар хугацаатай нийцсэн эсэх.
- Аудитын компанийн захирал нь мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрхтэй, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтээс зохих зөвшөөрөлтэй байх.
- Аудитын хуулийн этгээд нь 3-аас доошгүй мэргэшсэн нягтлан бодогчтой байх.
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт заасан хориглолт, хязгаарлалтыг зөрчөөгүй байх,
- Төрийн аудитын байгууллагын захиалгаар сүүлийн 3 жил аудитын ажил гүйцэтгэж байсан туршлагатай байх, хэрэв ийм ажил гүйцэтгээгүй бол мөн хугацаанд бусад ижил төстэй ажил хийсэн туршлагатай байх,
- Үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагааны болон санхүү, бүртгэлийн баримт материалыг хүлээн авах, хадгалах, аудит хийх шаардлага хангасан ажлын байртай байх.
- Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.

2.Сонирхсон этгээд мэдүүлгээ дор дурдсан хаягаар 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 14 цагаас өмнө ирүүлнэ үү. Нэмэлт мэдээллийг 70422954, 70422930 тоот утсаар авч болно.

Хаяг:Баян-Өлгий аймгийн Засаг даргын тамгын газрын байрны 1 дүгээр давхар 103, 104 тоот өрөө

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар Утас:70422954, 70422930



БАТЛАВ ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
М.ХУАНГАН

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газраас 2021 оны санхүүгийн тайланд хараат
бус аудитын хуулийн этгээдээр аудит хийлгэх төсвийн байгууллагын жагсаалт

8317144071
БЮА0074 9007245

№	Байгууллагын нэр	Санхүүгийн тайланд аудит хийх хэлбэр
1	Сум дундын ойн анги	Бие даасан дүгнэлт гаргана
2	Аймгийн Номын сан	Бие даасан дүгнэлт гаргана
3	Аймгийн Музей	Бие даасан дүгнэлт гаргана
4	Биеийн тамир, спортын газар	Бие даасан дүгнэлт гаргана
5	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	Бие даасан дүгнэлт гаргана
6	"Өлгий Сансар" эмнэлэг	Бие даасан дүгнэлт гаргана
7	Алтай сумын хүүхдийн цэцэрлэг	Бие даасан дүгнэлт гаргана
8	Алтанцөгц сумын хүүхдийн цэцэрлэг	Бие даасан дүгнэлт гаргана
9	Баяннуур сумын хүүхдийн цэцэрлэг	Бие даасан дүгнэлт гаргана
10	Бугат сумын хүүхдийн цэцэрлэг	Бие даасан дүгнэлт гаргана
11	Булган сумын хүүхдийн цэцэрлэг	Бие даасан дүгнэлт гаргана
12	Булган сумын Ёлт хүүхдийн цэцэрлэг	Бие даасан дүгнэлт гаргана
13	Буянт сумын хүүхдийн цэцэрлэг	Бие даасан дүгнэлт гаргана
14	Дэлүүн сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг	Бие даасан дүгнэлт гаргана
15	Дэлүүн сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэг	Бие даасан дүгнэлт гаргана
16	Ногооннуур сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг	Бие даасан дүгнэлт гаргана
17	Ногооннуур сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэг	Бие даасан дүгнэлт гаргана
18	Сагсай сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг	Бие даасан дүгнэлт гаргана
19	Сагсай сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэг	Бие даасан дүгнэлт гаргана
20	Сагсай сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэг	Бие даасан дүгнэлт гаргана
21	Толбо сумын хүүхдийн цэцэрлэг	Бие даасан дүгнэлт гаргана
22	Улаанхус сумын Хөххөтөл хүүхдийн цэцэрлэг	Бие даасан дүгнэлт гаргана
23	Цагааннуур тосгоны хүүхдийн цэцэрлэг	Бие даасан дүгнэлт гаргана
24	Цэнгэл сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг	Бие даасан дүгнэлт гаргана
25	Цэнгэл сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэг	Бие даасан дүгнэлт гаргана
26	Цэнгэл сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэг	Бие даасан дүгнэлт гаргана
27	Цэнгэл сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэг	Бие даасан дүгнэлт гаргана
28	Өлгий сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль	Бие даасан дүгнэлт гаргана
29	Өлгий сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль	Бие даасан дүгнэлт гаргана
30	Өлгий сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль	Бие даасан дүгнэлт гаргана
31	Өлгий сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль	Бие даасан дүгнэлт гаргана
32	Өлгий сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургууль	Бие даасан дүгнэлт гаргана
33	Өлгий сумын Ерөнхий боловсролын 7 дугаар сургууль	Бие даасан дүгнэлт гаргана
34	Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургууль	Бие даасан дүгнэлт гаргана
35	Өлгий сумын Ерөнхий боловсролын 9 дүгээр сургууль	Бие даасан дүгнэлт гаргана

БЭЛТГЭСЭН: АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК